



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/141

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газраас Мөрөн суманд баригдах 900 хүний суудалтай Хөгжимт драмын театрын барилгын зураг төслийг 2013 онд захиалж хийлгэсэн бөгөөд тухайн барилга баригдах газрын байршлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 11 дүгээр сарын 13-ний өдрийн ээлжит бус XII хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан “Мөрөн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд нийцүүлэн өөрчилж, газар эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Идэрмөнх	(Мөрөн сумын Засаг дарга)
Ж.Даваадамдин	(Аймгийн Соёл, урлагийн газрын дарга)
Б.Энхжаргал	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
З.Нямбаяр	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)
Х.Даваасүрэн	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Н.Шинэбаяр	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын БХБХ-ийн мэргэжилтэн)
Д.Нямбат	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын БХБХ-ийн мэргэжилтэн)
Э.Дэлгэрмөрөн	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ГУХ-ийн мэргэжилтэн)
Ш.Баасанпүрэв	(Мөрөн сумын архитектор, дэд бүтэц, нийтийн тээвэр хариуцсан ажилтан)
С.Мөнх-Эрдэнэ	(“Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв” ХХК-ний захирал)
Б.Банзрагч	(Хөгжимт драмын театрын дарга)

6717010531

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Ганзориг

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

2. Дээрх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, явцыг тухай бүр танилцуулан ажиллахыг Ажлын хэсэг (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН